

“ХӨХӨӨ НАМЖИЛЫН ДОМОГ”- ООС МОНГОЛЧУУДЫН ИТГЭЛ БИШРЭЛ ХИЙГЭЭД ӨНГӨ, ТООНЫ БЭЛГЭДЭЛТ СЭТГЭЛГЭЭГ ШИНЖЛЭХ НЬ

*Сити Их Сургууль, Хүмүүнлэгийн сургуулийн Боловсрол судлалын тэнхимийн багш.
Жамъяндоржийн Алтаннавч, Доктор.(Ph.D)*

Э-мэйл: J.Altmnvch@gmail.com
ORCID: 0009-0002-3109-492X

Хүлээн авсан 2023.05.10, Засварласан 2023.09.08, Хэвлэлтэнд 2023.09.12

Хураангуй

Аливаа домгийн агуулгын тоймоос үзэл сэтгэлгээг шинжлэх нь үзэгдлээс мөн чанарыг илэрхийлэх явдал бөгөөд тухайн үндэстний сэтгэлгээний онцлогийг тодорхойлоход чухал хэрэглэгдэхүүн болох юм. Энэхүү судалгаанд морин хуурын үүсэлтэй холбоотой домгуудыг цуглуулж, эмхэтгэн Хөхөө Намжилын домгийн хувилбар гэгдэх “нэгэн залуу нисдэг хүлэг морио муу санаатны гарт алдсанаар морин хуур урлаж байгаа” гол мотивоор зангилагдсан 15 домгийг шүүн авч, гол санаа, өгүүлэмж, дүрээрээ нэгэн домгийн хувилбар болохыг батлав. Судалгаандаа түүхэн материалын арга, төрөл хуваах арга, текст задлалын арга, мотив судлалын арга ба харьцуулан шинжлэх аргыг голлон хэрэглэсэн.

Тус домгуудаас монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээг шинжлэхийн тулд зан үйл, соёл судлал, гоо зүйн сайхны тухай онолыг ашиглан “сэтгэхүйн ертөнцдөө хүслийн жигүүрт хүлэг болон Этүгэн эхийн дүрүүдийг бүтээсэн” байгааг шинжлэн тогтоов. Эдгээр дүрүүд нь домогт жонон хар морь, нисдэг жигүүрт хүлэг, лусын дагина, Алтайн охин зэргээр дүрслэгдэх бөгөөд хийморь хэмээх хийсвэр ухагдахууныг жигүүрт хүлэг болгон итгэж, уул усны эзэн сахиусыг лусын охин, дагина хэмээн ахуйчлан шүтэж, бэлгэшээсээр ирсэн болох нь нотлогдлоо.

Монгол хүний сүсэг бишрэлээс төрөгдсөн өнгө (ногоон өнгөөр лус буюу лусын эзнийг, хар өнгөөр хар яст харц хүн, эрэлхэг зориг, цог жавхланг, улаан өнгөөр халуун дотно, баяр баясал) болон тооны (нэг, хоёр, гурвын тоо) бэлгэдэл домог ярианд туссан байгаа нь үйл явдал, өгүүлэмжээр батлагдаж байна.

Энэхүү судалгааны үр дүн нь судлаачдын судалсан хэсэг бусад хуурын домгийн судалгааг улам гүнзгийрүүлж, цар хүрээг өргөтгөн, нэгэн домгийн хувилбаруудаас монголчуудын оор соёл, узуур сэтгэлгээг шинжилснээрээ ач холбогдолтой бөгөөд морин хуурын домгийн судлалд анхдагч болж байна.

Түлхүүр үг: *Хөхөө Намжилын домог, морин хуур хөгжим, монголчуудын бэлгэдэл сэтгэлгээ*



This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license. ©2022 Author(s)

Оршил

Морин хуурын домгийн тухай аман уламжлалыг цуглуулан, ном бичигт тэмдэглэн эмхэтгэн найруулсан бүтээл байх авч нарийвчлан судалж, нэгтгэн харьцуулж, үнэлгээ шинжилгээ хийн, Монголчуудын узуур сэтгэлгээг тодотгон илрүүлсэн нь цөөн юм. Морин хуурын домог нь зөвхөн Монгол туургатных болохын хувьд Монгол улс, Өвөрмонголоор голлох судалгаагаа хийх нь зайлшгүй юм. Энэ талаар хийгдсэн өмнөх судалгааг дурдвал:

Монгол утга соёлыг судлаач С.Дулам “Монгол домог зүйн дүр” гэх бүтээлдээ үлгэр, дуу, хуур хөгжим үүссэн домгийг тусгай хэсгээр өгүүлж, “Үлгэр, дуу, хуур хөгжмийн үүслийг эртний домгийн соёлт баатруудаас эхлээд эгэл хүн бүтээл болгон хэлэлцэх хоёр янзын өгүүлэмжтэй байна гэж тодорхойлсон [1] бол хөгжим судлаач Ж.Энэбиш “Монгол хөгжмийн их нүүдэл” цуврал номдоо “Морин хуурын үүслийг хуурын татлагаас тодруулах нь” гэсэн хэсгээр Хөхөө Намжил, Сүхийн саарал, Алаг дааганы домог, Аргасун хуурчийн домог, Жороо морины татлагыг жишээлэн өгүүлж, “Хөхөө Намжилын домог, Жороо морины татлагаас хэдэн зуун жилийн өмнө морин хуур буюу хуурын төрлийн чавхдаст хөгжмийн зэмсэг, тэдгээрт зориулсан хөгжмийн бүтээлүүд (татлагууд) түгэн дэлгэрч домогшжээ” гэж дүгнэсэн байдаг. [2]

Хөгжим судлаач Д.Энхцэцэг “Хуурын татлага-монголын хөгжмийн феномен болох нь” бүтээлдээ морин хуурын домгийн 3 хувилбарыг дурдаад “Хөхөө Намжил бол 18-р зууны дунд үеэр Балдан засгийн хошуу, одоогийн Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт төрж өссөн, Алтайн хилийн манаанд алба хааж байсан бодит хүн” гэж үзсэн байна [3]. Харин Өвөрмонголын утга соёл судлаач Хүрэлшаа “Хөхөө Намжил, Сүх хүү бол мал аж ахуйн үед үүссэн домог бөгөөд энгийн малчин ба соёлт баатар мөн гээд домгийн гол баатар улам ахуйч шинжтэй болсон” гэж шинжилсэн [4].

ӨМИС-ийн профессор Төгсбаяр “Ажнай үүрслийн анхны уянга <Илдэн морины татаас>” хэмээх өгүүлэлдээ, дуун домог буюу хөгжмийн домгийг анх Жин улсын (Jin Chao) үеийн Цүй Бао (Cui Bao)-ийн зохиосон “Эртэн эдүгээгийн хадлага” (Gu Jin Zhu) гэдэг бичигт “Жороо морины татаас” хэмээх нэртэйгээр тэмдэглэсэн байдаг. Энэ домгийг судалж үзээд “Малчин монгол угсаатны түүх соёл ба монгол үндэстний үлгэр тууль лугаа нэгд нэгээрээ нийцэж, оньс товчоороо дүйцэж байх тул Хятадын уламжлалаас төрөгдсөн домог биш, харин Монгол өндөрлөгийн малчин угсааны домог нь Дундад хязгаарт уламжлагдан орж, хятад бичгээр тэмдэглэгдэж үлдсэн байна” хэмээн цаг хугацааны баримжааг тодорхойлсон байна [5]. Бээжингийн Их сургуулийн профессор Дулаан “Монгол ардын аман зохиолын харьцуулсан судлал” номондоо, одоогоор морин хуурын үүсэл гаралтай холбоотой 10 гаруй домог цуглуулаад байгаа ба “Сүхийн саарал”-ын хэв маягтай, “Хайр сэтгэлийн хэв маягтай”, “Бурхан чөтгөр хамтран бүтээсэн хэв маягтай”, “Хаянхярваа Дамрин бурханы хэв маягтай” гэж 4 ангилан авч үзсэн байна [6]. Дээрх судалгаанаас гадна морин хуурын домгийг тусгайлан авч судалсан судалгаа байхгүй бөгөөд хэсэг бусад мэдээллийн чанартай ном товхимолд тэмдэглэн үлдээх нь олширсон байна. Энэ талыг дараагийн түвшинд хүргэн, нөхвөр судалгааг хийхийн тулд морин хуурын үүсэлтэй холбогдох домгуудыг цуглуулж, ангилан нэгтгэж, харьцуулан дүгнэж, түүнээсээ Монголчуудын үзэл сэтгэлгээг илрүүлж, уламжлал шинэчлэлийг тодруулахыг зорьлоо.

Энэ өгүүлэлд Хөхөө Намжил – хүлэг морь – бүсгүй гэсэн дүрүүдэд зангилагдаж, хүлэг сайн морь нь хэн нэгэн хорон санаатанд жигүүрээ хайчлуулж үхсэнээр морин хуур хөгжим үүсэх шалтгаан болж буй домгуудыг цуглуулан судалж, нэгэн домгийн хувилбар болохыг баталсан. Мөн монголчууд итгэл бишрэлийн сэтгэлгээнээсээ улбаалан жигүүрт хүлэг, этүгэн эхийн дүрүүдийг бүтээсэн болох, түүнчлэн өнгө, тоогоор бэлгэдэх үзлээ домог яриандаа хэрхэн шингээн уламжлуулсныг олж тогтоов.

Судалгааны арга зүй

Тус судалгааны ажлын цар хүрээг Монгол улс болон Өвөрмонгол гэж тогтоон түүхэн материалын арга, төрөл хуваах арга, текст задлалын арга, мотив судлалын арга, харьцуулан судлах арга, зан үйлийн зүй, соёл судлал ба гоо зүйн сайхны тухай онол аргыг хэрэглэв. Өвөрмонголын Алшаа, Цахар, Ордосоор 6 сарын хугацаатай хээрийн шинжилгээгээр явахдаа нутгийн ард иргэдтэй уулзалт ярилцлага хийх, эх хэрэглэгдэхүүнийг сурвалжлан тогтоох, ном сурах бичгийг шүүх зэргээр ажиллалаа. Мөн Монгол улсын Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны сан хөмрөгийн гар бичмэл болон соронзон бичлэгийн хадгаламж зэрэг үнэ цэнтэй сурвалжид түшиглэн харьцуулан судалсан.

Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

А. Монголчуудын бэлгэдэл сэтгэлгээний аман хүүрнэл “Хөхөө Намжилын домог”-ийн хувилбарууд

Монгол ардын аман зохиолын домгийн төрөлд “Хөхөө Намжилын домог” томоохон байр эзэлдэг. Энэхүү домгоос монголчуудын сэтгэлгээний онцлогийг шинжлэхийн тулд газар газар тархсан хувилбаруудыг нэгтгэн цуглуулж, үйл явдал, өгүүлэмж, дүрийн давтамжид тулгуурлан нэгэн домгийн хувилбар болохыг батлах оролдлого хийв.

Хувилбар 1. “Монгол ардын домог үлгэр” дэх “Хөхөө Намжилын домог”-т “Эрт цагт Хөхөө Намжил гэгч сайн эр баруун Алтайд цэрэгт татагдан алба хааж байхдаа нэгэн гүнжтэй танилцана. Намжилыг буцах болсонд “жонон хар” морио дурсгал болгоно... Намжил жонон хар морио унаж шөнө бүр гүнжтэй уулзсаар нэг л мэдэхэд 3 жил болжээ. Баяны ховч хүүхэн үүнийг ажиглаж мэдээд, жонон хар мориных нь жигүүрийг хайчилсанд морь нь үхэв. Намжил үүнээс болж хайртай гүнжтэйгээ, хайртай хүлэг морьтойгоо дахин уулзаж чадахгүй болсондоо туйлын их гашуудаж, морин хуур хөгжмийг урлан бүтээжээ гэж гардаг [7].

Хувилбар 2. “Хөгжмийн уламжлал шинэчлэлийн асуудалд” номон дахь “Хөхөө Намжилын домог”-т “Намжил хугацаагүй цэргийн албанд татагддаг. Төрсөн нутаг, аав ээж, амраг ханиа санахын эрхээр дуулдаг түүнийг Алтайн дагина сонсож мэдээд нисдэг хурдан хүлгээ өгч тусалжээ. Намжил энэ хүлгээ унаж шөнөд нь гэртээ, үүрээр харуулын байрандаа очдог болж гэнэ. Нэгэн удаа хар санаатай хүн түүний нисдэг хурдан хүлгийнх нь гуурсыг тас хяргасанд хүлэг нь үхжээ. Ингээд Намжил сэтгэл санаагаа засахын тулд морин хуурыг үйлдэн бий болгожээ” [8].

Хувилбар 3. “Алшаа ардын аман зохиолын цомог” дахь “Морин хуурын үлгэр” бол Өвөр монголд тархсан хувилбарын нэг юм. “Хөхөө Намжил гэдэг харц ардын адуучин хүүд баян айлын бач ихтэй хүүхэн дурлан, эд мөнгө, эрх сүрээрээ далайлган байж гэрлэжээ. Харилцан хайр сэтгэл гэж үгүйн тул Хөхөө Намжил олон жил лусын хааны охинтой сэтгэлийн үгээ хэлэлцэж, харгис хаан, хартай эхнэрийнхээ зовлонг мартдаг байв. Нэгэн удаа хаан адуун сүргээсээ морь бариулах гээд түшмэдээ явуулсанд Хөхөө Намжил эзгүй, түүний оронд нэгэн догшин харцгай адуун сүргийг манаад огт ойртуулсангүй. Үүнээс хойш хартай харгис эхнэр нь түүнийг мөшгин хардсаар лусын охинтой уулздагийг нь, түүний унаж буй хүлэг нь нисдэг жигүүртэй болохыг мэдээд хайчилж орхисонд морь нь үхжээ. Хөхөө Намжилын сэтгэлд хар үүл бууж гашуудан, морио дурсахын тулд хуур хөгжим зохиожээ” [9].

Хувилбар 4. “Алшаа зүүн хошууны аман үлгэр” дэх “Хөхөө Намжил” гэх энэ хувилбарт “Намжил ганц бүдүүн хар морио унаж асган орой алга болдог ба өглөө агнасан ан ч үгүй, усан хулгана болсон морьтой харьж ирэхэд эхнэр нь хардлын сэтгэл

төрөх болсоор удаж гэнэ. Тэр нутгийн хаан түүнийг сайн адуучин гэж мэдээд адуучин болгож гэнэ. Нэгэн өдөр хаан хоёр тахартаа адуун сүргээс морь барихыг даалгасанд Намжил эзгүй, түүний оронд хоёр хөхөө шувуу адууг нь манаад тэднийг ойртуулсангүй. Тахрууд энэ мэдээг хаанд хүргэв... Нэг өглөө Намжилын авгай нь хогоо хаяхаар гарахдаа сайр дээр хөрвөөж буй жонон хар морины суганаас жижигхэн хөөрхөн алтан жигүүр цухуйж байхыг нь үзээд буцан гүйн орж хайч авчраад хайчилж орхисноор эгэл биш эрдэнийн морь нь үхэв. Намжил эг сэггүй гурван долоо хоног хийсэн хуураа хуурдаж суутал нэг их хуй салхи ирээд, тэр хуураа орхиод алга болжээ. Эдүгээ нутгийн ардууд тэнгэрийн дагина нь ирээд аваад явчихсан” гэж ярьдаг [10].

Хувилбар 5. “Алшаа зүүн хошууны аман үлгэр” дэх “Хөхөө Намжил” домог нь хувилбар 3,4-тэй ижил үйл явдал өрнөдөг ба түүний адуун сүргийг лусын хүүхний томилсон 4 хараацай манадгаараа ялгаатай [11].

Хувилбар 6. “Алшаа зүүн хошууны аман үлгэр” дэх “Хөхөө Намжил” домогт “Цэргийн агт хариулдаг Намжил далайн хөвөө барьж адуундаа явдаг ба их сайхан хоолойгоор уянгалуулан дуулдаг байжээ. Түүний сайхан дуулахыг нь лусын хүүхэн сонсоод уярч, түүгээр дуу заалгамаар байгаагаа хэлж далайн гүн дэх орд харшдаа аваачсан гэнэ. Тэд өдөр болгон уулзаар Хөхөө Намжил түүнтэй ханилжээ. Нэгэн удаа Намжил лусын хүүхэндээ би гэрээ эргэмээр байна гэхэд хуруу инчдэхийн зуур хүссэн газраа хүрдэг жонон хар морь өгчээ. Тэр морь нь хоёр жигүүртэй бөгөөд ба таван өнгийн солонго татдаг ид шидтэй гэнэ. Шөнө болгон гэртээ хонохоо больсон нөхрийнхөө энэ учрыг авгай нь мэдээд мориных нь жигүүрийг хайчилсанд, шархаа даалгүй үхэв гэнэ. Хөхөө Намжил морио санахдаа нэг хуур хийгээд гурван жил хуураа татаж, хүлгийнхээ сэгийг эргэн үзсээр байтал суган дахь жигүүр нь ургаж гүйцээд Намжил ч үзэгдэхээ байсан гэнэ” [12].

Хувилбар 7. “Монгол ардын аман зохиолын чуулган” дахь “Хөхөө Намжилын домог”-т ногоон торгон дээлтэй лусын хүүхэнтэй ханилсан Хөхөө Намжилын тухай өгүүлнэ. Өмнө дурдсан домгуудын адилаар “Цэргийн албанд байхдаа зөвхөн дуу дуулах ба лусын хүүхэн уярч сонсоод дуу заалгахаар гэртээ аваачиж, адуун сүргийг нь тусгай хүн гарган мануулдаг. Намжил хэдийгээр сайхан амьдарч байсан ч орон нутагтаа хүлээн суух аав ээж, амраг гэргийтэй тул аргагүй явах болов. Лусын хүүхэн түүнд сайхан хул морь өгөөд түүнээс өөр морь унаж болохгүй, саахалтын хирд түр зогсож амьсгааг нь дараад очиж байгаарай гэж учирлан захисаар явуулжээ. Ингэж тэд хүлэг мориныхоо ачаар 3 жил уулзсан боловч нэг өдөр авгай нь мэдэн мориных нь гуурсыг хайчилж орхижээ. Хөхөө Намжил эмгэнэн гашуудаж, 3 сар шахам нойр хоолгүй хэвтсэний эцэст морио дуурайлган морин хуур хөгжим хийж” гэнэ [13].

Хувилбар 8. “Алшаа зүүн хошууны аман үлгэр” дэх “Алтан харуулд морь шагнасан нь” домог ярианд адуу харуулын газарт ардуудад алба тусгаж 3 жилээр татан, адуу хариулуулдаг байжээ. Нэгэн ядуу залуу энэ хэцүү албанд татагдан очоод лусын охинтой танилцдаг. Гол үйл явдлууд бусад домгийн адил өрнөх ба домог яриан төгсгөлд лусын хүүхэн нь “Би таныг аваачихаар ирлээ. Манай лусын оронд очиж энэ зохиосон хуураа татаж, дуулж хуурдвал их буян болно” гэж залуугийн зүүдэнд ирдэг. Зүүдний ёсоор болж лусын хүүхэн хилэн хар морио унаж ирээд түүнийг авч явсан гэнэ. Түүнээс хойш залуу үзэгдэхээ больж, эхнэр нь түүний амьд үхсэнийг сураглаад ч сураг чимээ олсонгүй гэнэ [14].

Хувилбар 9. “Монголын зан аалийн үлгэр” дэх “Хөхөө Намжил” -ын хувилбарт аз бусаар цөллөгөнд явж буй ардын яруу дууч Хөхөө Намжилын тухай гардаг. Түүнийг улсын эзэн авхай өрөвдөн хайрлаж, нэг хос жигүүрт сахиулсан хүлгээ өгч гэнэ. Тэд уулзан ярилцаж, алтан наран уулын цаанаас цухуйхад салж явдаг болжээ. Үүнийг мэдсэн Хөхөө Намжилын эхнэр нь сахиулсан хүлгийнх нь жигүүрийг хайчилж шатаасанд хүлэг морь нь шархаа даалгүй үхжээ. Хөхөө Намжил мориныхоо хойноос харуусан

гашуудахдаа морин хуур гэх хөгжмийн зэмсэг зохиож, дуулж хуурдаж сэтгэлийн шаналалаа тайлдаг болж гэнэ [15].

Хувилбар 10. “Хуурын татлага - Монголын хөгжмийн феномен болох нь” ном дахь нэгэн хувилбарт сарлагийн гунан хөх бяруу уналагатай, Хөхий уулаар нутагтай Намжил хүү цэргийн албанд татагдан очоод Алтайн савдагтай ханилж буй тухай гардаг [16]. Энэ хувилбарт Намжилын эгэл биш мориных нь суганы гуурсыг хайчилдаг хүн бол түүний эхнэр биш, хоньчны хар эм гэж гардгаараа бусад домгийн хувилбараас ялгаатай байна.

Хувилбар 11. “Хуурын татлага- Монголын хөгжмийн феномен болох нь” ном дахь өөр нэг хувилбарт нэгэн идэр баатар хайртай хүүхэн болох уулын дагинадаа шөнө бүр довтолгон ирдэг байтал тэр зуур харьяа цэрэг нь холдсоор, уулзан учрах аргагүйд хүрэв. Хурдан хүлэг нь газрын холыг туулж барахааргүй болсныг сэтгэлт хоёр мэдэж, арга ядахдаа хайртай хүүхэн нь хайрлан энэрэх сэтгэлдээ хүлэг морийг жигүүртэй болгосон ч харин нэг л шөнө уулзахгүй бол өөрөө амиа алдах ёстой байж гэнэ. Энэ бүхнийг мэдсэн хорон санаат эмгэн шуламс залууг ирэхийг отоож байгаад хүлгийнх нь шидэт жигүүрийг хурц хутгаар тас огтлоход сайхан хүлэг нь амь тавина. Хүлэг мориныхоо төлөө гашуудан гансравч, хайртай хүүхэн нь бас үхнэ гэж бодохоор орчлон харанхуйлах шиг болж гэнэ. Гэнэт гайхалтай санаа төрөн мориныхоо эд эрхтнээр нь морин хуур хөгжим хийж гэнэ [17].

Хувилбар 12. “Монгол домог зүйн дүр”-ийн “Балчин кээрийн домог”-т хоёр хайсан тогоо нэрэхийн зуур гадаад далайг эргээд ирдэг тийм хурдан сайхан хээр морьтой архичин залуугийн тухай үйл явдал гардаг. Уг домог нь Хөхөө Намжил гэх нэрээр тархаагүй ч түүний энэ сайхан хүлэг нь муу хүнд гуурсаа хайчлуульж байгаагаараа Хөхөө Намжилын домогтой холбогдож байна. Архичин залуу дайсанд хорлогдсон морио үзэн гашуудаж, мориныхоо толгойг дуурайлган сийлж, морин хуур хөгжмийг бүтээв гэнэ [18]

Хувилбар 13. “Монгол домгийн чуулган” дахь “Хөхөө Намжилын домог”-т Саруул гүний хошуу, одоогийн Увс аймгийн Цагаанхайрхан суманд нутаглаж байсан Намжил гэж тодорхой нэр устай залуугийн тухай өгүүлдэг. Энэ домог ярианд баян Хөхүй уулын савдагтай ханилдаг байсан Намжил баруун Алтайд цэргийн албанд очоод Алтайн савдагтай нийлж байна. Нутагтаа буцах болоход Алтайн савдаг хүлэг сайн морь бэлэглэх ба морь нь замдаа хорлогдож, Намжил зовж зүдэрч байгаа тухай дүрслэгддэг байна [19].

Хувилбар 14. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэнгийн нутгийн аялгууны сан хөмрөгийн гар бичмэлийн хэсэгт байгаа уг домгийг анх 1972 оны 3 сарын 11-д сурвалжлан, Анчны үлгэр /Хөхөө Намжил/ нэртэйгээр тэмдэглэн үлдээсэн байна [20].

Домгийг хувилбаруудтай харьцуулж үзвэл цэрэгт татагдаж буй, ногоон торгон дээлтэй бүсгүйтэй танилцаж буй, гуурст хүлэг мориороо агшин зуур ирж очиж байгаа зэрэг үйл явдал, өгүүлэмжийн хувьд адил боловч эхнэр нь цэрэг цуглуулан нөхрөө барих, жигүүрт хүлгийнх нь жигүүрийг хуга мушгих үйлүүд ялгаатай. Хамгийн гол нь домгийн төгсгөлд морин хуур урлаж байгаа гол мотив үгүй юм. Гэсэн хэдий ч уг домгийн дийлэнх өгүүлэмж Хөхөө Намжилын домгийн хувилбартай адил байна.

Хувилбар 15. Монгол Улсын Урьдын эх Дагинын отог, одоогийн Төв аймгийн Эрдэнэсант сумын “Саруул зам” нэгдлийн төвд оршин суугч Дэмчигийн Дамбийжанцанаас 1973 оны 7 сарын 24-нд Д.Дашдорж уг яриаг тэмдэглэн авч, 2004 оны 1 сарын 28-нд Б.Катуу Хэл зохиолын хүрээлэнгийн сан хөмрөгт Д.Дашдоржийн гар бичмэлээр бүртгэн үлдээсэн байна. Домогт “Хөхөө Намжил Алтайн хязгаарт харуулын албанд яваад тэнд дуулж байхад нь Алтайн бүсгүй савдаг нөхөрлөж, нэгэн нисдэг гуурстай морь өгснөөс оройд нь гэртээ ирж, өглөө Алтайд бэлэн очдог байжээ. Гэтэл Хөхөө Намжилын айлын нэг хүн харуулын албанд Намжилтай хамт байсан авч, Намжил шиг ирж чаддаггүй байсан учир

тэр түүний эхнэр атаархаж, гуурстай мориор нисэж ирээд байгааг нь мэдсэн учир, нэг удаа сэм Намжилын морины гуурсыг хяргаснаас болж, морь нь үхээд, Хөхөө Намжил ийнхүү нааш цааш явж чадахаа больсон гэнэ” [21]. Хувилбар 14,15-р домгийн үйл явдал ерөнхийдөө бусад домгуудтай адил боловч гуурст морио алдсанаас болж морин хуур хөгжим бүтээж буй гол мотив байхгүй.

Table 1. Mythological content

	Legend name	Spreading area	Connection between main events	About how he mourned the death of his beloved horse	About how the fiddle was created
Version 1	The Legend of Khukhoo Namjil	Mongolia	A true man named Khukhoo Namjil, a princess, a black horse, a liar woman, cut off the wings.	Inside, he was filled with sorrow and grief...	Carved the head of a black horse out of wood, bent a stalk to the head, made a face from the hide, trimmed the tail with hair, and applied tree resin.
Version 2	The Legend of Khukhoo Namjil	Mongolia	Khukhoo Namjil, the singer-a mermaid-a fairy-flying horse-a lady-cut the secret wings.	He mourned the death of his precious horse, which shortens the month to day and the day to hour.	Horsehead fiddle was made.
Version 3	The Tale of the Fiddle	Alshaa	Khukoo Namjil, a horseman - a mermaid - a magic horse - a lady – cut off a golden wing.	Darkness covered his heart, and suffered from sadness all day long.	Taking the horse's tail, tuned it to the fiddle carved with a horse's head, and composed a tune for it.
Version 4	Khukhoo Namjil	Alshaa	Khukhoo Namjil, a hunter-a fairy of the sky-incarnate knight-lady-clipped the tip of the horse's wings.	He concerned about ...	made a horsehead fiddle and sawed off with the tail to make a tune.

Version 5	Khukhoo Namjil	Alshaa	Khukhoo Namjil is a horseman of a landlord - mermaid – a jeweled horse – a lady-cut off the wing	Remembering the horse made him lose his composure.	Made a horsehead fiddle.
Version 6	Khukhoo Namjil	Alshaa	Khukoo Namjil, a horseman who takes care of a military herd –a mermaid – a reincarnated horse – a lady – cut off the wings.	Missing his precious horse.	Made a fiddle and played a tune called “jonon har”.
Version 7	The Legend of Khukhoo Namjil	Mongolia	A good man named Khukhoo Namjil, a mermaid, a fine horse, a lady,	after his horse death, he was devastated and laid without food or sleep for almost 3 months.	Carved an imitation of a horse's head, made a fiddle with a horse's head, and entered a tune the story of his horse galloping.
Version 8	Awarded horse by Golden guardian	Alshaa	A poor young man – a mermaid – a velvet black precious horse –a lady- cut off the wing	Grieving to the point of death, he was next to the dead body of his horse	Made a square box out of wood, turned the tail into strings then carved a horse head, 2 wooden ears and 2 more or less matching handles. Finally created a kind of instrument.
Version 9	Khukhoo Namjil	Mongolia	A folk singer named Khukhoo Namjil – State miss – horse with a pair of wings - the lady- cut off the wing.	He deeply mourned.	Carved the head of a fiddle out of wood, put it on the neck of the fiddle, fixed it on a box covered with horse skin, tied two strings to the horse's tail and made a bow, pulled it melodiously, and made the sound of horse neighing, galloping, and stepping.

Version 10		Mongolia	A poor boy named Namjil-Altai mountain's spirit-winged horse-shepherd's jealous woman-cut off the wings .	The son was mourned.	Made a fiddle out of a horse's head, covered it with skin, and made strings out of its hair then he played it and the boy became Khuhu Namjil.
Version 11		Mongolia	A hero-a mountain fairy-evil witch- cut off the magic wings.		Made a wooden box, made a bow out of his horse's ribs, and a string out of his hair.
Version 12	The Legend of Balchin sorrel horse	Mongolia	A drunken young man-Balchin sorrel horse-evil man-cut the wings' pipe	Regretted.	The head was carved by imitating his horse head, the mane and tail were shaved then setting the horse's galloping tune.
Version 13	The Legend of Khukhoo Namjil	Mongolia	Khukhoo Namjil - Khukhui mountain's spirit- black horse-Altai mountain's spirit	Regretted.	
Version 14	A hunter's tale [Khukhoo Namjil]	Mongolia	A yong singer named Khukhoo Namjil- a girl in a green silk robe -winged horse- cut off the wing.	The dark haze pull.	
Version 15	The Legend of Khukhoo Namjil	Mongolia	Khukhoo Namjil - Altai's spirit - winged horse- cut off the wing.	I no can go to walk away and tither.	

Домог яриан судлалд 1. Цаг хугацаа, 2. Газар орон, 3. Хүн, 4.Үйл явдлыг тогтворжуулан авч үздэг нь үлгэрээс ялгагдах үндсэн зөрөө болдог [22]. Эдгээр домгийн цаг нь “эрт урьд цагт, эрт цагт, урьд цагт” гэхчлэн ерийн товч хэлбэрээр эхэлж байгаагаараа ижил. Нэрийн тухайд ихэнх нь Хөхөө Намжил гэгч гол дүрээр нэрлэгдсэн боловч 8-р хувилбарт “Алтан харуулд шагнасан морь” [23] хэмээх ондоо нэртэй байна. Энэ хувилбарын “Урьд алтан харуул гэж байв... буйд зэлүүд уйтгартай газар” гэснээс ажиглавал аглаг, алс хол, баруун Алтайн хязгаарыг зааж байгаа нь тодорхой. Харин гурван жилээр адуу хариулах гэдэг нь цэргийн албанд татагдах гэсний өөр хувилбар юм.

Амаар дамжин уламжлагдахдаа Алтайн харуул нь Алтан харуул болж хувирсан бөгөөд домгийн гол өгүүлэмж ч “Хөхөө Намжилын домог” үйл явдалтай дүйцэж байна.

Дүрийн хувьд Хөхөө Намжил буюу Намжил гэх залуу, түүний эхнэр, лусын хүүхэн, уулын савдаг гэсэн голлох хэдхэн дүртэй. Харин хувилбар 11-т Хөхөө Намжил бус нэгэн идэр баатар, хувилбар 12-т архичин залуу гэж гардаг. Хамгийн чухал нь энэ 2 домгийн гол мотив болох “хүлэг морь нь жигүүрээ хайчлуулсан тул үхэж, эзэн нь харуусахдаа морин хуур урлаж байгаа” нь Хөхөө Намжилын домгийн хувилбар болохоо баталж байна. Мөн хувилбар 14,15-д яг эсрэгээрээ тус домгийн үйл явдал ижилхэн өрнөх боловч гуурст мориных нь гуурсыг хайчилсны дараа морин хуур хийж байгаа гол мотив нь үгүй. Гэсэн ч гол дүр Хөхөө Намжил, Алтайн дагины хийж байгаа үйлдлүүд нь тус домгийн хувилбар гэдгээ нотолдог.

Домгийн цуглуулж эмхэтгэсэн байдлаас авч үзвэл 15 домог ярианы 5 нь ӨМӨЗО-ны Алшаа аймаг, 10 нь Монгол улсад харьяалагдаж байна. Монгол улсад тархсан домгийн хувилбарууд Монголын зүүн хязгаараас баруун хязгаар Алтай хүртэлх орон зайд үйл явдал өрнөж байдаг бол Өвөр монголын Алшаа нутгийн хувилбаруудад онцгойлон газар нутгийг зааж нэрлээгүй байна. Алшаагаас олдсон 5 хувилбар, Монгол улсын 4 хувилбараас бусад нь хэн, хэзээ, хаанаас бичиж тэмдэглэж авсан эх сурвалжийн мэдээлэл тодорхойгүй. Хэрвээ Алшаа нутгаар тархсан домгуудаас барагцаалж үзвэл Монгол улсын Говь-Алтай, Баянхонгор аймгуудад энэхүү домог яригддаг байсан гэж таамаглаж байна. Үүнийг тодруулж түүхийг эргэн сөхвөл “1930-аад оны эхээр Монгол улсын нийгэм, улс төрийн тогтворгүй байдал, зөрчилдөөнөөс болоод Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий, Дорнод зэрэг Өвөр монголтой хиллэдэг бүх л аймгийн хүмүүсийн дийлэнх нь эх орноо орхин хил даван дүрвэсэн. Тэр ч байтугай Говь-Алтай аймгийн урд сумдын хүн ам нь бараг л бүгдээрээ дүрвэж гарсан” гэх тэмдэглэл байна [24]. Иймд судалгаанд ашиглаж буй “Хөхөө Намжилын домог” нь дүрвэгчдээр дамжин тархсан байх магадлал хамгийн бодитой болох юм. Гэтэл энд тус домгийн анхдагч эх сурвалж яагаад Монгол улсынх вэ? гэдэг асуулт ургаж гарна. Монгол улсын Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны сан хөмрөгт хадгалагдаж буй домгийн 2 хувилбарыг 1970-аад оны эхээр Б.Катуу тэргүүтэй аман зохиол судлаачид өв тээгчдээс тэмдэглэж, соронзон хальснаа буулгасан. Эдгээр эх сурвалж бол бидэнд олдоод байгаа хувилбаруудын цаг хугацааны хувьд хамгийн эхнийх тул үүгээр баримжаа болгож үзэж болно. Мөн уг домог нь одоогоор Өвөр монголын зөвхөн Алшаад тархсан, Монгол улсын нийт хүн амд тархсанаараа Монгол улсынх болохоо дахин баталж өгч байна.

Хураангуйлбал, Морин хуурын дүрс, хэлбэр, бүтэц нь бүр мориноос үүсэлтэйг домгийн хувилбарууд батлахын зэрэгцээ голлох хэдэн мотивоороо нэгэн домгийн хувилбар болохыг илтгэж байна. Мөн Хөхөө Намжилын домог нь Монгол улсад анхлан тархаад, дараа нь Өвөр монголд дэлгэрсэн байна.

Б. “Хөхөө Намжилын домог” дахь монголчуудын итгэл бишрэлийн сэтгэлгээний тусгал

Аливаа домгийн агуулгын тоймоос үзэл сэтгэлгээг шинжлэх нь үзэгдлээс мөн чанарыг илэрхийлэх явдал болно. Энэ хэсэгт “Хөхөө Намжилын домог”-ийн хувилбаруудаас монголчуудын итгэл бишрэлийн сэтгэлгээг дараах байдлаар өгүүлнэ.

1. **Жигүүрт хүлгийг бишрэн шүтэх сэтгэлгээний тусгал.** Монголчууд сэтгэхүйн ертөнцдөө хүслэнгийн жигүүрт хүлгийн дүрийг бүтээгээд, түүнийгээ бишрэн шүтэж, улмаар домог яриандаа тусгасан байдаг. Үүний хамгийн тод жишээ бол Хөхөө Намжилын унаж яваа жигүүрт хүлэг юм. Энэ хүлэг бол угтаа аз хийморийн бэлгэдэлт дүр болно.

Хийморь гэдэг нь төвдөөр “lün rta” буюу “хийн (салхин) морь” гэсэн утгатай үг. Эртний Энэтхэгийн “тэжээхүй ухаан”, дандарын ёс буюу Бурханы очирт хөлгөний ёсны ойлголт бөгөөд хүний бодол санаа ямар нэгэн хий унаа хөлөглөж, түүнийхээ хүчээр хүрэх газраа хүрч, үйлдэх үйлээ үйлддэг” гэсэн ойлголт юм [25]. Угтаа унаж эдэлдэг мориноос гадна хүний биеийн дотор байх хийг “амь баригч хий” гэж нэрлээд морин дүрсээр илэрхийлж, хийморь хэмээн ярих болжээ. Хэрэв амь баригч хий хямрах аваас үүн дээр тогтдог сэтгэл хямарч, гуньж гутарч сөрөг үр дагавар үүсдэг учиртай. Тэгвэл домгийн бүх хувилбарт жигүүрт хүлгийн жигүүр нь хайчлагдсанаар зол бус тавилан, үхэл хагацал тохиож, сэтгэлийн их шаналанд унаж байна. Энэ нь монголчуудын хэлдэг “Хийморь нь доройтож, хишиг буян нь зайлах”-тай адил өгүүлэмж төдийгүй монгол хүний хийморийг бэлэгшээх сэтгэлгээгээр морио дахин амилуулж сэргээх гэсэн үзэлт болно. Үндсэндээ домгийн жигүүрт хүлэг бол хүмүний сэтгэл зүрхэнд орших хийморийн дүрийн ахуйчилсан хувилбар болж байна.

Мөн хувилбар 12-т “Хөхөө Намжилын хувилгаан морь суниахад суганаас нь жигүүр цухуйх бөгөөд таван өнгийн солонго татдаг” [26]-аас “Бурхан багш нирван дүрийг үзүүлэхдээ тэргүүний үснээс нь 5 өнгийн гэрэл гарч 5 манзуршир болон хувилсан” [27] бурханы шашны гэрэл гялбааг эрхэмлэх үзэлт илрэх ба агуулга, цар хүрээг улам тэлсэн жигүүрт хүлгийн дүрийн бас нэгэн хувилбарт дүр болж байгаа юм. Түүнчлэн үлгэр туульд гардаг “Үүлтэй тэнгэрийн доогуур, үзүүртэй модны дээгүүр” нисдэг хүлэг морьтой адил уул усыг алгасан, цаг хугацааг товчлон нисдэг гэж дүрслэгдсэнээрээ уран сэтгэмжит дүр болон хувирав. Энэ мэт хувилбарт дүрийг бүтээсэн домог дахь жигүүрт хүлэг нь монголчуудын итгэл бишрэлээс төрөгдөн бий болсон байна.

2. Уул ус, этүгэн эхийг бишрэн шүтэх сэтгэлгээний тусгал. Хөхөө Намжилын домог яриан бүх хувилбарт гарч буй лусын охин, Алтайн дагина, уулын савдаг гэгч эм үүтгэлтэй дүр нь энэхүү газар дэлхий, этүгэн эхийн өөр нэг хэв шинжит дүр болно. Уг дүр нь домог зүйн үүсэл хөгжлийн эхний үед юм үзэгдлийг амьдчилах, хүмүүншүүлэх сэтгэлгээнээс үүсэлтэй бөгөөд амилагч, үүсгэгч, үүдэгч гэх агуулгатай ухагдахуун гэж эрдэмтэд үздэг. Монгол хэлний их тайлбар тольд: 1.Эх болсон дэлхий, газар шороо 2.Эм удган, бөө гэж тайлбарласан байна. Энэ нь үр шим төгөлдөр эх газрыг нэрлэж байгаагаас гадна газар дэлхийн эзэн савдгийг давхар илэрхийлэх утгатай.

Судлаач Х.Буянбатын бичсэнээр: “Эхчлэлийн нийгмийн үед бөө мөргөлийн шашны үйл хэргийг эрхлэн гүйцэтгэдэг нь “удган” хэмээгдэх эмэгтэй бөө байжээ. Эмэгтэй бөө болох тэдгээр удган нь модны шүтлэгийг багтаасан газар дэлхийн шүтлэгийг эх этүгэний шүтлэг хэмээгдэх ойлгогдохуунтай болгосон байна. Үүний үр дүнд модны шүтлэгийн хүрээнд “удган мод” буй болж, тэр нь угтаа этүгэний бүрэлваа болжээ. Тухайн модонд эмэгтэй бөөгийн эзэд сахиус, онгод шүтээн оршдог” [28] хэмээгээд “Үүдлийн өлзий мөртэй, үржлийн үрийн хутагтай эмэгтэй шүтээн, эх шүтээн”-ий ойлголтыг улам тодорхой болгосон юм [29]. Домогт өгүүлэхээр газар доороос гэнэт гараад ирэх, далай дотроос гарч ирэх, хад хавцлыг хагалан гарч ирэх зэрэг өгүүлэмжүүд нь эгэл жирийн бус эзэн савдгийн шинжтэй ба Хөхөө Намжилыг нутагтаа очихыг хүсэхэд лусын дагина гэнэт алга болж, түүний байсан газар нь эмээл хазаартай морь эзнээ хүлээх шиг газар цавчлан зогсох дүрслэлээс этүгэн эхийн дүр маань уул ус, лус савдгийн эзэн хэмээх олон дүрд хувилж, хувилбарт домгуудыг үүсгэснийг харж болно. Энэхүү монгол хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшлээс төрсөн этүгэн эхийн дүр нь одоо ч аман зохиолын бүхий л төрөлд оршсоор байгаагийн илрэл нь Хөхөө Намжилын домог дахь эдгээр эм үүтгэлт дүрүүд болно.

Үүнээс үзэхэд монголчуудын итгэл бишрэлийн сэтгэлгээ нь ямар нэгэн хийсвэр ухагдахууныг бодитой болгон ахуй амьдралдаа буулгаж, амьдчилан үзээд түүндээ сүслэн биширч, сэтгэлийн их таашаалыг хүртдэг болохыг мэдэж болно.

В. “Хөхөө Намжилын домог” дахь монголчуудын бэлгэдэл сэтгэлгээний тусгал

Монголчуудын бэлгэдэл зүй, бэлгэ тэмдгийн ертөнцтэй танилцсанаар тэдний биет болоод биет бус соёлын өвийн онцлогийг таньж мэдэх, улмаар монгол утга соёлын нууцын чанадад нэвтрэх боломжтой. Энэ хэсэгт Хөхөө Намжилын домог ярианд илэрсэн монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээг өнгө ба тоо гэсэн хоёр талаас шинжилье.

1. **Монголчуудын өнгийг эрхэмлэх бэлгэдэлт сэтгэлгээний тусгал.** Байгаль, нийгэм, хүмүүний оюун санааны ертөнцөд өнгөөр тэмдэглэж үл болох юм үзэгдэл гэж бараг үгүй. Иймд монголчуудын эртнээс шүтдэг шүтээнээ өнгөөр хэрхэн дохиолж ирсэн язгуур сэтгэлгээг судалж үзвэл “Цагаан өнгөөр бөөгийн онгодын сэтгэлийг, хөх өнгөөр тэнгэрийг, ногооноор лусыг, улаанаар нар, галыг, хараар савдаг шивдэг” гэх мэтчилэн төлөөлдөг байжээ [30]. Морин хуурын үүслийн домогт хар, ногоон, улаан, шар зэрэг өнгөөр дүрүүдээ тодотгох ба тухайн өнгөний бэлгэ чанарыг дүрийнхээ уугал чанартай хамтатган итгэл үнэмшил, сүсэг бишрэлийн амьд дүр болгон домогложээ. Тухайлбал: лусын хүүхэн, ногоон торгон дээлтэй охин, хар ногоон хүлэг морь зэрэг нь цөм лусыг төлөөлж буй. Лус гэдэг бол ус, усны эзэн. Газар эхийн биеэр ус хэмээх амин судас гүйж, биеийг сэргээж, нөхөж байдгийн адилаар хуурын сайхан ая эгшиг хүн бүрийн сэтгэлийн шаналал, уйтгар гунигийг үргээж, баяр баясал бэлэглэх хөгжимдүүр болж байна. Иймийн тул лус хийгээд түүнтэй холбоотой дүрүүд гол дүрийн залууд ямар нэгэн байдлаар нөлөөлж, морин хуур үүсэхэд гол шалтгаан болж байна. Нөгөө талаар ногоон өнгийг газар дэлхий, үржил шим, хайр сэтгэлийн бэлгэ тэмдэг гэж үздэг тул хүлэг морио хүндлэн хайрлахын учир дахин амилуулан, сэтгэл зүрхэндээ оршоож, нийгэм нийтэд түгээн дэлгэрүүлэх аялгуу сайхан ая эгшигийг бүтээж байна. Мөн ногоон өнгөөр “өвс ногоо, цэцэг навчны урган төлжих, цэцэглэн дэлгэрэх” [31] цаг хугацааг илэрхийлдгээс урин дулаан зуны дэлгэр цагт домгийн үйл явдал өрнөж буйг анзаарч болох юм.

Улаан өнгийг монголчууд эртнээс нааш халуун дотно, баяр баясгалан, баатар зориг, сүр жавхааг илтгэдэг гэж бэлэгшээж ирсэн. Домог дахь “Алтайн дагина элгэн улаан хадыг хагалж гарч ирдэг” [32] өгүүлэмж нь улаан өнгөт хад чулууг ер бусаар шүтэж ирсэн монгол хүний сэтгэлгээн илрэл юм. Судлаачид “Улаан өнгөт хад чулууг шүтэх нь балар эртний хүмүүсийн ан агналын соёлоос үндэстэй гэж таамагласан байдаг. Тэд хүн амьтны сүнсийг цусанд байна гэж үздэг. Цус бол улаан өнгөтэй. Тэгэхээр улаан өнгөт хад чулууг хүн амьтны сүг сүнс буюу эзэд сахиус оршиж байх онцгой юм хэмээн шүтдэг” [33] хэмээснээс харвал элгэн улаан хадыг хагалж гарч ирж буй дагина бол монголчуудын бүтээсэн эзэн сахиусын бэлгэдэлт дүр яахын аргагүй мөн.

Хар өнгө бол домог яриан бас нэгэн чухал дүр болох амраг хоёрыг учруулж, хонгор хоёр зүрхийг баясгахад хүчээ өгч байсан хүлэг морины зүс юм. Энэ хүлэг морь нь ихэнхдээ хар буюу хилэн хар гэж дүрслэгддэг. Монгол утга соёл судлаач С.Дулам “Бэлгэдэл зүй” бүтээлийнхээ “Өнгийн бэлгэдэл” хэсэгт “Төрийн харуул хайчийн хүнд албанд зүтгэгсдийн буюу хар яст харц хүний унах хүлэг нь тас тэмдэггүй хар морь байдаг” [34] гэж тодорхойлсон нь Хөхөө Намжил бол цэргийн албанд татагдсан ядуу залуу юм гэдгийг давхар баталж өгсөн билээ. Мөн эртнээс “Хар өнгө бол хүч чадал, эрэлхэг баатар, цог жавхаагийн бэлгэдэл” [35] болж ирсэн болохоор жонон хар мориог домог яриандаа амилуулан бүтээж, цаг хугацаа, орон зайг товчилдог увдист дүр болгон бэлэгшээжээ. Харин хувилбар 7-д лусын охин сайн хул морио ядуу залууд бэлэглэдэг. Хул морь гэж санамсаргүй хэлсэн зүйл биш бөгөөд “Алтан (цагаан) яст хан ноёдын сурвалж бүхий хүний хүлэглэдэг хүлэг нь алтан шарга(л), аранзал зээрд, халиун, хонгор, хул зэрэг гэгээн зүсмийн морьд байдаг” [36] хэмээх тодорхойлолтыг баталж байна. Энэ мэтчилэн монголчуудын өнгийг эрхэмлэх, түүнийг бэлэгшээн үзэх сэтгэлгээ нь домогт далд утга санаагаар оршиж, анхдагч төсөөлөлтэйгээ үндэс язгуур холбоотой байсаар байгааг харуулж байна.

Монголчуудын тоог эрхэмлэх бэлгэдэлт сэтгэлгээний тусгал. Монголчууд “тэгш тоог энэ ертөнцийнх, сондгой тоог нөгөө ертөнцийнх” гэж сэтгэх ёс байдаг. Морин хуур нь бүхэлдээ нэгийн тооны бэлгэдэл. Учир нь хоёр хялгасан утасны нэг (“фа”утас) 150 ширхэг хар өнгөтэй азарганы хялгасаас бүрдэж, хоёр дахь нь (“си бемоль” утас) 120 ширхэг цагаан өнгөтэй гүүний хялгасаар бүрэлдэж, нумны утасны 90 ширхэг хялгастай нийлээд 360 ширхэг болдог нь нэгэн бүтэн тойргийн градусын тоотой тэнцэнэ. Бүтэн тойрог үүсгэж буй нь нэг буюу түүний бэлгэдэлт чанартай шууд холбогдох бөгөөд “андын барилдлагын эв санааны нэгдэл болон хам олны эв эе”[37]-ийг илэрхийлж байна. Чухамдаа домогт эзэндээ туйлын үнэнч хүлэг сайн морь, үхсэний дараа ч орхиж чадахгүй байгаа эзэн хүний сэтгэлийг эв нэгдэл, хам олны санаагаар гаргаж байгаа нь бэлгэдлийн утгаар ингэж тайлагдаж байгаа юм. Мөн морин хуур нь хоёр чих, хоёр тэвх, хоёр хялгастай байдаг ба тэдгээрийг хоёрын тооны бэлгэдэлт утга, арга билгийн хослол гэж ойлгож болох төдийгүй ахуй амьдралын бодит зүйл гэж хүлээн авч болно. Өөрөөр хэлбэл хазгай хэлтгийгүй, эв эе, арга билгийн бэлгэдэл болсон уг тоон утгаар Хөхөө Намжил хийгээд түүний үнэнч сайн нөхөр хүлэг морь, мөн Хөхөө Намжил хийгээд нэгэн эмэгтэй гэсэн хослолуудыг харуулж, хорвоо ертөнц бол аливаа зүйлийн хослол, хамтралжил байдаг гэсэн санааг илтгэж байна.

Түүнчлэн монгол ардын бэлгэдэл зүйд гурвын тоогоор цаг хугацааг хэмжих, болзох, ажил үйлийн бүрдлийг илэрхийлэх бөгөөд эдгээр хувилбаруудад гурвын тоо олонтаа давтагдана. Тухайлбал, хүлэг морио үхсэний дараа 3 жил сахин суутал гэнэт амилах, гурван жил хуураа татаж хүлгийнхээ сэгийг эргэн үзсээр байтал суган дахь жигүүр нь гэнэт ургаж гүйцэх, эг сэггүй гурван долоо хорин нэгэн хоног хуураа татаж санаа болж суухад нь лусын хүүхэн нь ирээд аваад явах зэргээр өгүүлж буй нь аливаа юмны охь шимийн бүрэлдэх цаг хугацааг хэмжих дээрх санааг далд утгаар илэрхийлж байна.

Дүгнэлт

Морин хуурын үүсэлтэй холбогдох 50 гаруй домгийн хувилбаруудыг цуглуулан, харьцуулж үзээд “нисдэг хүлэг морьтой нэгэн залуу хорон санаатны гарт түүнийгээ алдаад, гашуудан харуусахдаа морин хуур хөгжим урлаж байгаа” гол мотивтой Хөхөө Намжилын домгийн 15 хувилбарыг түүж авав. Уг домгуудын агуулгыг хураангуйлбал “амь – үхэл – итгэл” гэсэн гурван зүйл дээр зангилагдах бөгөөд тэд бүгд нэгэн домгийн хувилбар болохыг үйл явдал, өгүүлэмжээр нь баталлаа. Зарим хувилбарын тухайд Хөхөө Намжил бус нэгэн идэр баатар, архичин залуу гэх зэргээр гардаг боловч “хүлэг морь нь жигүүрээ хайчлуулсан тул үхэж, эзэн нь харуусахдаа морин хуур урлаж байгаа” гол өгүүлэмжээ хадгалан үлдсэн тул тус домгийн хувилбарын баталгаа гэж үзэж байна. Мөн хувилбар 14,15-д яг эсрэгээрээ домгийн үйл явдал ижилхэн өрнөх боловч жигүүрт мориных нь жигүүрийг хайчилсны дараа морин хуур хийж байгаа төгсгөлийн мотив нь үгүй. Гэсэн хэдий ч гол дүр Хөхөө Намжил, лусын дагины хийж байгаа үйлдлүүд нь тус домгийн хувилбар болохыг илтгэнэ. Мөн эдгээр домог нь Монгол улсад үүсээд Өвөр монголд тархсан болохыг эх сурвалжийн мэдээллээс тогтоов.

Түүнчлэн эцэг тэнгэр, эх дэлхий, уул усны лус савдаг болон аз хийморийг бэлгэдэх жигүүрт хүлгийн дүрийг ахуйчлан бүтээж, түүнийгээ шүтэн бишрэх, аргадан залбирах сэтгэлгээгээ домог яриагаар уламжлуулан дамжуулахдаа олон хувилбарт дүрийг бүтээсэн болох нь тодорхой байна. Мөн эзэн - хүлэг хоёроор эв эе, хам цуг, аливаа зүйлийн хослол, хамтралжил зэрэг “нэг, хоёр”-ын тооны утгат чанарыг бэлгэдэхийн зэрэгцээ цаг хугацааг гурваар хэмжин бүрдэл боловсролын утгыг илтгэх өгүүлэмж давтагдаж байгаа нь нотлогдож байна.

Хөхөө Намжилын домгуудын дүр, мотивыг ингэж харьцуулан судалж, нэгтгэн шинжилсэн нь аман зохиол судлалд анхдагч бөгөөд цаашид бусад домгийг нарийвчлан судлах суурь судалгаа болж байгаагаараа ач холбогдолтой.

НОМ ЗҮЙ

1. Дулам,С. (2009). *Монгол домог зүйн дүр*. Улаанбаатар: Битпресс.х.298
2. Энэбиш,Ж. (2017). *Монголын хөгжмийн их нүүдэл*. Улаанбаатар:Адмон.х.112-113
3. Энхцэцэг,Д. (2018).*Хуурын татлага-Монголын хөгжимт соёлын феномен болох нь*. Улаанбаатар.х.19
4. Хүрэлшаа. (2016). *Монгол домгийн соёл судлал*. Улаанбаатар:Адмон принт.х.45
5. Төгсбаяр. (2010) *Ажнай үүрслийн анхны уянга <Илдэн морины татаас>” өгүүлэл*, Өвөр Монголын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл. 1-р хугацаа, №1
6. Дулаан. (2001).*Монгол ардын аман зохиол*. Бүгд Найрамдах Хятад Ард Улс: Бээжингийн Их Сургуулийн хэвлэлийн газар.х 54-55
7. Цэрэнсодном,Д. (1989). *Монгол ардын домог үлгэр*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
8. Энэбиш,Ж. (1991). *Хөгжмийн уламжлал шинэчлэлийн асуудалд*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
9. Сарана,Ч. (2009). *Алиша ардын аман зохиолын цомог*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.
10. Төмөрбөх,Хатачган.,Сарана,Ч. (2017). *Алиша зүүн хошууны аман үлгэр*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо. х. 358-360.
11. Төмөрбөх,Хатачган.,Сарана,Ч. (2017). *Алиша зүүн хошууны аман үлгэр*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо. х.360-363
12. Төмөрбөх,Хатачган.,Сарана,Ч. (2017). *Алиша зүүн хошууны аман үлгэр*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо. х. 363-364.
13. Цэрэнсодном,Д. (1982). *Монгол ардын аман зохиолын чуулган*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. х.49
14. Төмөрбөх,Хатачган.,Сарана,Ч. (2017). *Алиша зүүн хошууны аман үлгэр*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо. х. 381-384.
15. Мандах.,Хасчимэг. (1997). *Монголын зан аалийн үлгэр*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Үндэсний хэвлэлийн хороо.
16. Энхцэцэг,Д.(2018).*Хуурын татлага-Монголын хөгжмийн феномен болох нь*. Улаанбаатар. х.115
17. Энхцэцэг,Д.(2018).*Хуурын татлага-Монголын хөгжмийн феномен болох нь*. Улаанбаатар.х.116
18. Дулам,С. (2009). *Монгол домог зүйн дүр*. Улаанбаатар: Битпресс.х.278
19. Сампилдэндэв,Х.(2010). *Монгол домгийн чуулган*. Улаанбаатар.х.384-386
20. Монгол улсын Шинжлэх Ухааны Академи – Хэл зохиолын хүрээлэн. *Дуун ухааны сан хөмрөг. №385-72. Х-6.Тов.данс-1. Хадгаламжийн нэгж-5*
21. Монгол улсын Шинжлэх Ухааны Академи – Хэл зохиолын хүрээлэн. *Дуун ухааны сан хөмрөг. №385-72. Х-5. Тов.данс-31. Хадгаламжийн нэгж -6*

22. Хүрэлшаа. (2017). Монгол үндэстний дуу хөгжмийн үлгэр үүслийн домог үлгэрийн эмгэнэлт жүжгийн шинжийг өгүүлэх нь. Өвөр Монголын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл.2-р хугацаа,№190
23. Төмөрбөх.Хатагчан.,Сарана.Ч. (2017). *Алиаа зүүн хошууны аман үлгэр*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо. х. 381-384.
24. Нийтлэл. (2016 оны 12 22). news.mn. <https://news.mn/r/753622/>
25. Дулам,С. (1979). *Галаар бэлгэдэх бэлгэдэл домог зүйтэй холбогдох нь*. Монгол Улсын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг.2-р хугацаа
26. Төмөрбөх.Хатагчан.,Сарана.Ч.(2017).*Алиаа зүүн хошууны аман үлгэр*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо. х. 363-364.
27. Сайнцогт,Х. (2011). *Ар зуу бүтсэн домгийг өгүүлэх нь*. Өвөр Монголын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл.6-р хугацаа
28. Буянбат,Х.(2016).*Монголчуудын модны шүтлэг*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.х.5
29. Буянбат,Х.(2016).*Монголчуудын модны шүтлэг*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.х.2
30. Дулам,С. (2000). *Монгол бэлгэдэл зүй*. Дэд дэвтэр. Улаанбаатар: Битпресс.х.33
31. Дулам,С. (2000). *Монгол бэлгэдэл зүй*.Дэд дэвтэр. Улаанбаатар: Битпресс.х.137
32. Энэбиш,Ж. (1991). *Хөгжмийн уламжлал шинэчлэлийн асуудалд*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.х.77
33. Буянбат,Х.(2016). *Монголчуудын модны шүтлэг*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.х.2
34. Дулам,С. (2007). *Монгол соёлын чуулган*. Улаанбаатар: Битпресс.х.316
35. Мандуга,Ван. (2011). *Монгол зан үйлийн судлал*. Өвөр Монголын Өөртөө Засах Орон: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.х.108
36. Дулам,С. (2007). *Монгол соёлын чуулган*. Улаанбаатар: Битпресс.х.316
37. Дулам,С (2007). *Монгол бэлгэдэл зүй*. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар:Адмон.х.3

AN ANALYSIS OF THE MENTALITY FOR MONGOLIANS' SYMBOLISM BASED ON THE MYTH OF "KHUKHU NAMJIL"

Altannavch Jamiyandorj

Ph.D Lecturer at the Department of Educational Studies,
School of Humanities, City University, Ulaanbaatar, Mongolia

E-mail: J.Altannavch@gmail.com

ORCID: 0009-0002-3109-492X

Received 10.05. 2023,

Revised 08.09.2023,

Accepted 12.09.2023

Abstract

Analyzing the symbolic mindset from an overview of the content of any myth is an expression of essence from phenomena, and it will be an important tool for determining the characteristics of the nation's mentality. Therefore, many legends of the origin of the Morin huur (Horsehead fiddle) were collected and compiled in the course of my research; then 15 selected myths which are called similar versions of Khuhu Namjil tied to the main motif with the main idea of "A young man who lost his magical flying horse to a villain was depressed and made fiddles for him" were confirmed that it's the same version of the same myth in terms of their main content, narrative, and characters. Accordingly, this research mainly used historical material, genre division, text analysis, motif, and comparative study methods.

In order to analyze the symbolic mentality of the Mongolians from the myths by using some theories of ritual, cultural studies, and aesthetics, it was analyzed and determined that "the characters of the horse with the wings of desire and the mother "Etugen" were created in their world of intellection". These characters are represented by the legendary "Jonon" black horse, flying winged horse, mermaid, and "Altai"s maiden and it was proved from the content that the abstract concept of spirit is believed to be as a winged horse, and the talisman of the owner of mountains and springs has been worshiped as a mermaid and a fairy for ages. In addition, it has been proved that the symbols of colors (such as green color representing "Lus" or the owner of Springs, black color as civilian, bravery, and splendor, and red color is as warmth and joy) and numbers (one, two, three) were created from Mongolian people's devotion and belief are reflected in the legend by using the events and the narratives in it.

Basically, by deepening and expanding the scope of the study of the legend of the fiddle, which previous researchers studied, and by clarifying the meaning of the event and the ideology or mindset of the characters, it is not only innovative but also brings one step closer to the further research of the legend related to the origin of the fiddle thus, the results of this research are significant and a pioneer in the study of fiddle mythology.

Key words: Legend of Khukhoo Namjil, the horsehead fiddle, the mentality of Mongolians' symbolism



This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license. ©2022 Author(s)